

**УКРАИН: ВИТАЛИНА КОВАЛ**

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ**

## **ЛГБТИ ХҮМҮҮСИЙГ ДЭМЖСЭНИЙХЭЭ ТӨЛӨӨ ХАЛДЛАГАД ӨРТСӨН**

Виталина Ковал үргэлж эерэг өөрчлөлт авчрахыг хүсдэг байсан. Тэрээр өөрийн төрөлх хот Узгородын ЛГБТИ хүмүүсийг үргэлж дэмждэг. Гэвч Виталина болон бусад идэвхтнийг үзэн ядалтын эсрэг дуугарсных нь төлөө үндсэрхэг үзэлтнүүдийн зүгээс халдаж дайрсан байна.

2018 оны 3 дугаар сарын 8 буюу Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Виталина эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийн төлөө тайван жагсаал зохион байгуулсан. Цагдаа түүнийг болон жагсагчдыг аюулгүй байлгана гэж баталж байсан.

Тухайн өдөр олон хүн тэднийг доромжлон

хашгирч, улаан будаг цацаж байсан ба Виталинагийн нүд химийн бодист түлэгджээ. Халдсан хүмүүсийг баривчилсан боловч хэдхэн цагийн дараа суллажээ. Түүнээс хойш Виталина болон бусад жагсагчид руу заналхийлэх нь нэмэгдэж, хоёр идэвхтэн зодуулсан байна.

Энэ халдлага нь Виталина шиг хүмүүсийг “эрүүл бус” гэж үздэг Украйны үндсэрхэг үзэлтнүүдийн хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтийн давалгааны нэг хэсэг аж. Гэвч энэ нь Виталина болон түүний адил хүний эрх хамгаалагчдыг айдаст автуулж чадахгүй юм.



**Украин улсын Дотоод хэргийн сайдад хандан Виталина болон бусад идэвхтнийг хамгаалахыг шаардана уу.**

Minister of Interior  
Vul. Akademika Bohomoltsa, 10  
Kyiv, 01601, Ukraine  
Email: pgmia@mvs.gov.ua  
Twitter: @AvakovArsen  
Facebook: www.facebook.com/arsen.avakov.1  
Salutation: Dear Minister



**Виталинад эв санааны нэгдлээ илэрхийлээрэй.**

■ Vitalina Koval  
■ Amnesty International Ukraine Office – postal box address  
■ POB 40  
■ 04050  
■ Kyiv  
■ Ukraine  
■ Twitter: @VitalinaKovalUA